



Төрийн Тусгай Албан  
Хаагчдын Нэгдсэн Эмнэлэг  
Амжилтын төлөө өөрчлөлт

# ЭМНЭЛГИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛЫН БАРИМТ БИЧИГ

ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ТТАХНЭ/202012004

УЛААНБААТАР ХОТ  
2020 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 29-НЫ ӨДӨР

## УРИЛГА

2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр

**Үнийн санал шалгаруулалтын нэр:** “ Эмнэлгийн цэвэрлэгээний материал ”

**Үнийн санал шалгаруулалтын дугаар:** ТТАХНЭ/202012004

**Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн** тендерт оролцогч эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь Цахим тендер зохион байгуулах журмын дагуу хураамж 50,000 /тавин мянган/ төгрөгөөр [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) –ээс оролцох эрхээ худалдан авна. Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг ажлын 7 хоног 2020 оны 05-р сарын 08-ны өдрийн 15 цаг-аас өмнө худалдан авах ажиллагааны цахим сайт болох [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан **2020 оны 05-р сарын 08-ны өдрийн 15 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Тооцно**

**Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо,

Хуульчдын гудамж

## **Нэг. ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- 1. Эрх бүхий оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Үнийн саналд оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Шалгуур үзүүлэлтэнд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Үнийн санал ирүүлэх, нээлт**
  - 2.1. Захиалагч нь ирүүлсэн үнийн саналын баримт бичиг Шалгуур үзүүлэлтэнд заасан захиалагчийн хаягаар, заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Баримт бичгийг Шалгуур үзүүлэлтэнд заасан хугацаанд, заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Баримт бичгийн иж бүрдэл**
  - 3.1. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх баримт бичиг нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) Татварын ерөнхий газрын тодорхойлолт
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн ирүүлсэн саналаас татгалзана.
  - 5.2. Оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 10 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
  - 7.1. Оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь Шалгуур үзүүлэлтэнд заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ**
  - 8.1. Захиалагч нь шалгарсан оролцогчид гэрээ байгуулах

**байгуулах  
эрх олгох  
тухай  
мэдэгдэл**

эрх олгосныг түүний хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ОӨЗ 1.1	<p><b>Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:</b> 2018, 2019 оны санхүүгийн тайланг ирүүлнэ.</p> <p><b>Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил:</b> Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага, 2018, 2019 оны 3-аас доошгүй гэрээ ирүүлнэ.</p> <p><b>Эрх бүхий оролцогч дараах нэмэлт материалыг хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Тусгай зөвшөөрөл, дистрибьютерийн эрх;</li> <li>• Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;</li> <li>• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт;</li> <li>• Татварын цахим тайлангийн системээс авсан тодорхойлолт;</li> <li>• Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;</li> <li>• Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тухай харилцагч банкны тодорхойлолт;</li> <li>• Бараа нийлүүлэлтийн хуваарь;</li> <li>• Баталгаат хугацаа /баталгаат хугацаат хариуцах гэмтэл, оношлогооны талаар дурдах/</li> <li>• Худалдагч тал валютын ханшны өөрчлөлт, онцгой албан татвар нэмэгдэх болон гэрээний хугацаанд гарах аливаа асуудлыг бие даан хариуцах ба гэрээний үнэд нөлөөлөхгүй гэсэн албан бичгээр ирүүлэх, Гүйцэтгэгчээр шалгарсан оролцогч барааг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх, уг техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бууруулсан талаарх дүгнэлт, хэрэглэгчийн гомдол, шаардлага гарсан тохиолдолд гэрээг цуцалж, дараагийн шаардлага хангасан оролцогчтой гэрээ байгуулахыг зөвшөөрсөн тодорхойлолт;</li> <li>• Үнийн саналын баримт бичгийн гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ</li> <li>• Оролцогчийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл (Оролцогч байгууллагын нууцад хамаарах мэдээллийг ялган ирүүлэх)</li> <li>• Лабораторийн дүгнэлт гаргуулах.</li> <li>• <b>Багцын бүтээгдэхүүн тус бүрийн материалын дээжийг ирүүлнэ.</b></li> </ul>
ОӨЗ 2.1	<p>Үнийн санал нээх хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>УБ хот, ЧД-ийн 4-р хороо, Хуульчдын гудамж</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>ТТАХНЭ-ийн 6-р давхар 605 тоот</b></p> <p>Огноо: <b>2020 оны 05 дугаар сарын 08-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>14 цаг 30 минут</b></p>
ОӨЗ 3.1	<p>Баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ажлын 5 хоногоос багагүй байна.</p>
ОӨЗ 3.2	<p>Оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх</p>

	бичиг баримт нь Монгол хэл дээр байна.
<b>ОӨЗ 3.3</b>	Оролцогч Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бараа нийлүүлэхтэй холбогдуулан үнийг бусад валютаар санал болгон ирүүлэхийг “зөвшөөрөхгүй.”
<b>ОӨЗ 3.4</b>	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: “шаардлагатай” <b>1 жилээс доошгүй байх.</b>

**ГУРАВ. БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА,  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

№	Цэвэрлэгээний материалын нэр	Хэмжих нэгж	Техникийн тодорхойлолт
<b>БАГЦ:-1 УГААЛГЫН БОДИС/ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭС/</b>			
1	Гарын тос	ширхэг	Цэцэг, жимсний фарфум үнэртэй, харшил үүсгэдэггүй, хүний арьсанд сөрөг нөлөөгүй байгалын гаралтай түүхий эд ашигласан, гар зөөллөх /240 грамаас доошгүй байх/ <b>/БАРХАТНЫЕ РУЧКИ-тэй дүйцэхүйц/</b>
2	Гарын шингэн саван	ширхэг	Цэцэг, жимсний фарфум үнэртэй, хир бохирдол арилгах актив бодистой, харшил үүсгэдэггүй, хүний арьсанд сөрөг нөлөөгүй байгалын гаралтай түүхий эд ашигласан, усанд хурдан задарч, зайлагддаг усанд хэмнэлттэй буюу байгал орчинд ээлтэй байх /240 грамаас доошгүй байх/ <b>/БАРХАТНЫЕ РУЧКИ-тэй дүйцэхүйц/</b>
3	Эдийн саван	ширхэг	Цэцэг, жимсний фарфум үнэртэй, хир бохирдол арилгах актив бодистой, харшил үүсгэдэггүй, өнгөт хувцас, хэрэглэлийн өнгийг сэргээж цагаан хувцас, хэрэглэлийг цайруулдаг төрөлтэй, хүний арьсанд сөрөг нөлөөгүй байгалын гаралтай түүхий эд ашигласан, усанд хурдан задарч, зайлагддаг усанд хэмнэлттэй буюу байгал орчинд ээлтэй байх /240 грамаас доошгүй байх/ <b>/LIBY-тэй дүйцэхүйц/</b>
4	Шил арчигч 1л	ширхэг	Байгалын гаралтай түүхий эд ашигласан, цэцэг, жимсний фарфум үнэртэй, харшил үүсгэдэггүй, байгаль орчинд ээлтэй байх, эмнэлэгт хэрэглэхэд тохиромжтой. Шилэн гадаргууд толбо үлдээж загалтуулахгүй, гүн цэвэрлэж, өнгөлж гялалзуулдаг байх <b>/MR.MUSCLE-тэй дүйцэхүйц/</b>
<b>БАГЦ:-2 ГЯЛГАР УУТ /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭС/</b>			
1	Хогийн уут /том/ задгайгаар	ширхэг	0.035 микроноос багагүй зузаантай, 100*120-аас багагүй, ус үл нэвтрэх, 5 кг-аас багагүй даацтай, амыг нь уях боломжтой, уутны гадна талд зохих тэмдэглээтэй, 1 боодолд байх тоо нь бүрэн гүйцэд байх ба заагдсан хэмжээтэй байх
2	Хогийн уут /том/ боодолтой	ширхэг	0.035 микроноос багагүй зузаантай, 100*120-аас багагүй, ус үл нэвтрэх, 5 кг-аас багагүй даацтай, амыг нь уях боломжтой, уутны гадна талд зохих тэмдэглээтэй, 1 боодолд байх тоо нь бүрэн гүйцэд байх ба заагдсан хэмжээтэй байх
3	Хогийн уут /хар/	ширхэг	0.035 микроноос багагүй зузаантай, 80*60-аас багагүй, ус үл нэвтрэх, 3 кг-аас багагүй даацтай, амыг нь уях боломжтой, уутны гадна талд зохих тэмдэглээтэй, 1 боодолд байх тоо нь бүрэн гүйцэд байх ба заагдсан хэмжээтэй байх

4	Хогийн уут /шар/	ширхэг	0.035 микроноос багагүй зузаантай, 60*55-аас багагүй, ус үл нэвтрэх, 3 кг-аас багагүй даацтай, амыг нь уях боломжтой, уутны гадна талд зохих тэмдэглээтэй, 1 боодолд байх тоо нь бүрэн гүйцэд байх ба заагдсан хэмжээтэй байх
<b>БАГЦ:-3 ЭЛГЭН АЛЧУУР /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭС/</b>			
1	Элгэн алчуур	ширхэг	Нийлэг эдийн агууламжгүй, ус шингээх чадвартай, эдэлгээ сайтай, эмнэлэгт хэрэглэхэд тохиромжтой. Шилэн гадаргууд толбо үлдээж загалтуулахгүй, гүн цэвэрлэж, өнгөлж гялалзуулдаг, зөөлөн бөгөөд өндөр нягтаршилтай, агшиж сунахгүй, завсрын өнгөтэй байна.
<b>БАГЦ 4:- ЦААСАН БҮТЭЭГДЭХҮҮН / ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭС</b>			
1	Гарын цаасан алчуур	ширхэг	Эрүүл мэндийн ажилтны гарыг угаасны дараа арчих зориулалт бүхий, усанд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй байна. 1 боодолдоо 200ш –ээс багагүй тоотой, 100% ариутгасан, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, Z эвхээстэй, татдаг байх
2	Амны сальфетка /сугалдаг/	ширхэг	MNS-4273-95 Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, усанд түргэн уусамтгай, ариутгагдсан, гель, тос , ус арчихад зориулагдсан 15*15-аас багагүй хэмжээтэй 1 боодолдоо 150-аас багагүй тоотой, 100% ариутгасан, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, Z эвхээстэй, татдаг байх
<b>БАГЦ:-6 АГААРЖУУЛАГЧ /ИМПОРТООР/</b>			
1	Агааржуулагч 300мл	ширхэг	Байгалын гаралтай түүхий эд ашигласан, цэцэг, жимсний фарфум үнэртэй, харшил үүсгэдэггүй, байгаль орчинд ээлтэй байх /glade-тэй дүйцэхүйц/
2	Агааржуулагч /автомат запас/ 269мл	ширхэг	Байгалын гаралтай түүхий эд ашигласан, цэцэг, жимсний фарфум үнэртэй, харшил үүсгэдэггүй, байгаль орчинд ээлтэй байх /glade-тэй дүйцэхүйц/
<b>БАГЦ:-7 БУСАД</b>			
1	Бээлий /цагаан/	хос	Даавуун материалаар хийгдсэн, резинэн товруутай, ажлын бээлий
2	Хүнсний бээлий /боодол/	ширхэг	100% ариутгасан, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, гялгар материалаар хийгдсэн байх
3	Бээлий /тоосны /	хос	Тохойноос урагш хэмжээтэй, нимгэн, резинэн материалаар хийгдсэн, чанартай байх
4	Бээлий /шалны/	хос	Тохойноос урагш хэмжээтэй, зузаан резинэн материалаар хийгдсэн, чанартай байх
5	Гал тогооны бээлий	хос	Тохойноос хойш хэмжээтэй, зузаан хөвөн даавуун материалаар хийгдсэн, халуун материал барихад зориулагдсан давхар хамгаалалттай байх
6	Бээлий урт /00/	хос	Тохойноос хойш хэмжээтэй, зузаан резинэн материалаар хийгдсэн, чанартай байх
7	Шалны алчуур /таар/	ширхэг	Цагаан өнгийн, хөвөн даавуун материалаар хийгдсэн, урт-130см, өргөн 65см-тэй, угаалт, мушгилт даах чадвартай, гарт харшил өгөх материалын агууламжгүй, эдэлгээ даах чадвартай, тохирсон өнгөтэй, урагдаж цоороогүй, бүтэн, ус сайн шингээдэг,



			үйлдвэрийн аргаар нүхэлсэн нүхтэй, үс, ноос татдаггүй, нийлэг биш, даавуун материалтай байна.
8	Крантны алчуур /шар/	ширхэг	50*70-аас багагүй хэмжээтэй, угаалт, мушгилт даах чадвартай, гарт харшил өгөх материалын агууламжгүй, эдэлгээ даах чадвартай, тохирсон өнгөтэй, урагдаж цоороогүй, бүтэн, ус сайн шингээдэг, үйлдвэрийн аргаар нүхэлсэн нүхтэй, үс, ноос татдаггүй, нийлэг биш, даавуун материалтай байна.
9	Суултуурын алчуур /улаан/	ширхэг	
10	Шүршүүрийн алчуур /цэнхэр/	ширхэг	
11	Шалны сойтог	ширхэг	Гүн хирийг сойтогдоход тохиромжтой, үсний өндөр 2 см-ээс дээшгүй, Гарт барихад эвтэйхэн, хана шал сойздоход тохиромжтой, үс нь хатуувтар, зөөлөн биш эдэлгээ сайтай байх.
12	Урт иштэй сойтог	ширхэг	Ишний урт 1-1.2 метрээс багагүй, хана, тааз угаахад тохиромжтой, бариул нь чанартай материалаар хийгдсэн, сойтогний үсний өндөр 2 см-ээс багагүй, Гарт барихад эвтэйхэн, үс нь хатуувтар, зөөлөн биш эдэлгээ сайтай байх.
13	Хүнсний скоч	ширхэг	Гялгар материалаар хийсэн, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, өргөн-40 байх. Нимгэн биш чанартай. 200-300метр урт
14	Тогоо угаагуур /төмөр/	ширхэг	Төмөр материалаар хийсэн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх
15	Автомат суултуур цэвэрлэгч	ширхэг	5 ширхэгээр савлагдсан.
16	Тогоо угаагуур	ширхэг	Ишний урт 50-60см-ээс багагүй. Төмөр материалаар хийгдээгүй байх. сойтогний үсний өндөр 2 см-ээс багагүй, Гарт барихад эвтэйхэн, үс нь хатуувтар, зөөлөн биш эдэлгээ сайтай байх. эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх
17	Хивс прож цэвэрлэгч	ширхэг	<b>Ваништай дүйцэхүйц</b>
18	Мебель өнгөлөгч	ширхэг	MNS-4273-95 стандартын шаардлага хангасан, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, 100% ариутгасан, усанд түргэн уусамтгай, ариутгагдсан, байгаль орчинд ээлтэй байх / <b>шүршдэг pronto-той дүйцэхүйц</b> /

## ДӨРӨВ. НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Цэвэрлэгээний материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь							
				5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
<b>БАГЦ:-1 УГААЛГЫН БОДИС/ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭС/</b>											
1	Гарын тос	ширхэг	600	75	75	75	75	75	75	75	75
2	Гарын шингэн саван	ширхэг	2,800	350	350	350	350	350	350	350	350
3	Эдийн саван	ширхэг	4,700	580	580	580	580	580	580	580	600
4	Шил арчигч 1л	ширхэг	480	60	60	60	60	60	60	60	60
<b>БАГЦ:-2 ГЯЛГАР УУТ /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭС/</b>											
№	Цэвэрлэгээний материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь							
				5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Хогийн уут /том/ задгайгаар	ширхэг	12,000	1,500	1,500	1,500	1,500	1,500	1,500	1,500	1,500
2	Хогийн уут /том/ боодолтой	ширхэг	8,400	1,050	1,050	1,050	1,050	1,050	1,050	1,050	1,050
3	Хогийн уут /хар/	ширхэг	48,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000
4	Хогийн уут /шар/	ширхэг	27,600	3,450	3,450	3,450	3,450	3,450	3,450	3,450	3,450
<b>БАГЦ:-3 ЭЛГЭН АЛЧУУР /ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭС/</b>											
№	Цэвэрлэгээний материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь							
				5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Элгэн алчуур	ширхэг	750	90	90	90	90	90	100	100	100
<b>БАГЦ 4:- ЦААСАН БҮТЭЭГДЭХҮҮН / ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭС</b>											
№	Цэвэрлэгээний материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь							
				5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Гарын цаасан алчуур	ширхэг	6,420	800	800	800	800	800	800	800	820
2	Амны сальфетка /сугалдаг/	ширхэг	400	50	50	50	50	50	50	50	50
<b>БАГЦ:-6 АГААРЖУУЛАГЧ /ИМПОРТООР/</b>											
№	Цэвэрлэгээний материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь							
				5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Агааржуулагч 300мл	ширхэг	720	90	90	90	90	90	90	90	90
2	Агааржуулагч /автомат запас/ 269мл	ширхэг	70	8	8	8	8	8	8	8	8
<b>БАГЦ:-7 БУСАД</b>											
№	Цэвэрлэгээний материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь							
				5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Бээлий /цагаан/	хос	500	60	60	60	60	65	65	65	65
2	Хүнсний бээлий /боодол/	ширхэг	45	5	5	5	5	5	5	5	10
3	Бээлий /тоосны /	хос	116	15	15	15	15	15	13	13	15
4	Бээлий /шалны/	хос	720	90	90	90	90	90	90	90	90
5	Гал тогооны бээлий	хос	10	1	1	1	2	2	1	1	1
6	Бээлий урт /00/	хос	140	15	15	15	20	20	20	20	15
7	Шалны алчуур /таар/	ширхэг	4,200	525	525	525	525	525	525	525	525
8	Крантны алчуур /шар/	ширхэг	1,200	150	150	150	150	150	150	150	150
9	Суултуурын алчуур /улаан/	ширхэг	600	75	75	75	75	75	75	75	75
10	Шүршүүрийн алчуур /цэнхэр/	ширхэг	600	75	75	75	75	75	75	75	75
11	Шалны сойтог	ширхэг	600	75	75	75	75	75	75	75	75

12	Урт иштэй сойтог	ширхэг	15	2	2	2	2	2	2	2	1
13	Хүнсний скоч	ширхэг	37	4	4	4	5	5	5	5	5
14	Тогоо угаагуур	ширхэг	150	18	18	18	20	20	20	18	18
15	Автомат суултуур цэвэрлэгч	ширхэг	170	20	20	20	20	20	25	25	20
16	Тогоо угаагуур	ширхэг	50	6	6	6	6	6	6	7	7
17	Хивс прож цэвэрлэгч	ширхэг	60	7	7	7	7	7	8	8	9
18	Мебель өнгөлөгч	ширхэг	100	12	12	12	12	12	15	13	12

## ТАВ. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## ЗУРГАА. ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний  |

гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

**10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах**

10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

**11. Маргааныг шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## НАЙМ. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулна.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Барааны нийлүүлэлтийн хуваарийн дагуу техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 3.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад гарсан гологдлыг тухай бүр шинэчлэн сольж өгнө.  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>- Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуухийнэ.</li><li>- Урьдчилгаа төлбөр: Байхгүй</li><li>- Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Байхгүй.</li><li>- Барааг хүлээн авахад төлөх төлбөр: 100 хувь /</li></ul> Барааны төлбөрийг гүйцэтгэлээр нь буюу бараа хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийг хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө. |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b>                              | 5.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн 7 хоног тутамд 0,5%<br>5.2. Алдангийн нийт дүн: 10% иас хэтрэхгүй байна.  |



**ЕС. ГЭРЭЭНИЙ МАЯГТ**  
Гэрээ байгуулахад харилцан тохиролцож өөрчлөлт оруулна.

**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч \_\_\_\_\_ нь нэр \_\_\_\_\_ төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]